



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/110

Улаанбаатар хот

Хяналт шалгалт зохион байгуулах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.3, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Улсын онцгой комиссын 2025 оны "Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн 1, 2 дугаар хороонд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж ажиллахыг дүүргийн менежер (Г.Дагвадорж), Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах), Тохижилт худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар), Багахангай тохижилт ОНӨААТҮГ (Б.Гэрэлмаа), хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлан ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-д, Үер усны аюулаас урьдчилан сэргийлж гамшигтай тэмцэх хүн хүч, техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг дүүргийн Ерөнхий болон Тусгай зориулалтын мэргэжлийн ангийн дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

2. Хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шалгах чиглэлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн
А/1110 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн

ахлагч:

Гишүүд:

Г.Дагвадорж

Б.Цогбадрах

Л.Санжийжамц

Д.Хүрэлбаатар

Б.Гэрэлмаа

Н.Нямзав

Б.Батзориг

Г.Ганзориг

Нарийн бичиг:

Ц.Мягмарсүрэн

Дүүргийн менежер

Онцгой байдлын хэлтсийн

дарга, хурандаа

Засаг даргын Тамгын газрын

дарга

Тохижилт, худалдаа үйлчилгээний
хэлтсийн дарга

“Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-
ын захирал

1-р хорооны Засаг дарга

2-р хорооны Засаг дарга

Онцгой байдлын хэлтсийн орлогч,
дэд хурандаа

Гамшгаас хамгаалах улсын
хяналтын байцаагч, дэслэгч

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн
А.110 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ШАЛГАХ ЧИГЛЭЛ

№	Шалгах чиглэл	Зохион байгуулах бүрэлдэхүүн
1	Үер, усны гамшгаас хамгаалах чиглэлээр гарсан тогтоол, шийдвэр, захирамж, албан даалгавар, Онцгой байдлын байгууллагаас өгсөн үүрэг, чиглэл зөвлөмжийн хэрэгжилт	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
2	Ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн ангиудын үер усны аюулаас урьдчилан сэргийлж гамшигтай тэмцэх хүн хүч, техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлыг шалгах	
3	Үерийн хамгаалалт, ус зайлуулах зориулалтын инженерийн барилга байгууламжид үзлэг хийх, далан, суваг, шуудууны цэвэрлэгээ ус чөлөөтэй нэвтэрч буй байдалд хяналт шалгалт хийж зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч ажиллах	
4	Гамшгаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг зохион байгуулах хор уршгийг арилгах үйл ажиллагааг зохион байгуулах шаардагдах хөрөнгө, нөөцийг бүрдүүлсэн эсэх	
5	Үерийн далан шуудуу сэтрэх, орон сууцны доод давхарт үерийн ус, хөрсний ус орохоос урьдчилан сэргийлж бэлэн байдлыг хангасан эсэх /гүүр, ус шингээх шуудай, элс, хайрга, шуудай/	
6	Үерийн дараах болзошгүй хор уршгаас үүдэлтэй халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хэрхэн зохион байгуулах ажлын бэлэн байдал	